

БАТЛАВ:



## ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН НЭМЭЛТ ГЭРЭЭ

2016 оны 06 сарын 02 өдөр

№8/1

Улаанбаатар хот

### НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Нэг талаас улсын бүртгэлийн дугаар 9011178046, регистрийн дугаар 5275156, харуул хамгаалалт эрхлэх 031 дугаартай “ЭМ БИ БИ БИ ТИ” ХХК-ийн “Харцага” Гэрээт харуул хамгаалалтын албыг төлөөлж Н.Дашпунцаг /цаашид үйлчлэгч тал гэх/ нөгөө талаас Цус сэлбэлт судлалын үндэсний төвийг төлөөлж Стратеги төлөвлөлт, санхүү бүртгэлийн албаны дарга Ч.Батболд /цаашид үйлчлүүлэгч гэх/ харилцан ашигтай хамтран ажиллах зорилгоор энэхүү гэрээг тохиролцож байгуулав.
2. Хамгаалагч талын зүгээс үйлчлүүлэгч талын БЗД-ийн 3-р хороо, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ард байрлах Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн шинээр ашиглалтанд орсон байр /цаашид объект гэх/ -ыг гэнэтийн болон гадны халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр болон хамгаалалтын алба хаагч ажиллуулах, үйлчлүүлэгч талын үйлчилгээний хөлс төлөхтэй холбогдсон харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.
3. Хоёр тал хамтран ажиллахдаа Монгол Улсын Үндсэн хууль, Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Иргэний хууль, байгууллагын дотоод журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
4. Гэрээний хоёр тал бие биенийхээ хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн



гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, үйл ажиллагаандаа хуулийг дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, албаны болон хувь хүний нууцыг чанд хадгалах зарчмыг баримтлана.

5. Хамгаалалтын ажилтан хоёрдмол удирдлагатай байна. Үйлчлүүлэгч тал нь өдөр тутмын удирдлага, хамгаалалтын алба нь мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.

6. Талууд харилцан тохирч, хамгаалалтын хүрээ хязгаар, түүнд харьяалагдах үйлчлүүлэгч объектын тоог нарийн тооцно.

7. Хамгаалалтын ажилтны эрх, үүргийг хамгаалагч ажилтантай байгуулсан гэрээгээр зохицуулна. Оролцогч талууд хамгаалалтын ажилтнаар энэхүү гэрээнд зааснаас өөр ажил үүргийг гүйцэтгүүлэхийг хориглоно.

### **ХОЁР: ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, НӨХЦӨЛ, ТӨЛБӨР ТООЦОО**

1. Энэхүү гэрээг 2016 оны 06 сарын 02-ноос 2016 оны 10 сарын 01-нийг хүртэл 4 сарын хугацаатайгаар байгуулав.

2. Гэрээний хугацааны төгсгөлд талууд гэрээг цуцлах, өөрчлөн шинэчлэх хүсэлт албан ёсоор бичгээр нэг сарын өмнө мэдэгдсэний үндсэн дээр зохих шийдвэрийг хамтран гаргана.

3. Хэрэв гэрээний хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө урьдчилан албан ёсоор ямар нэг мэдэгдэл, санал тавиагүй бол гэрээг цаашид сунгагдсанд тооцох бөгөөд гэрээг хугацаанаас өмнө аль нэг тал нь гэнэт цуцалбал 1 сарын төлбөртэй тэнцэх төлбөрийг төлнө.

4. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хамгаалалтын үйлчилгээний /цаг, хоног, сарын/ төлбөр нийт 1 150 000 /Нэг сая нэг зуун тавин мянган төгрөг, /НӨАТ ороогүй/ төгрөг байхаар тохиролцов.

5. Энэ төлбөрт НД, ЭМД, ХАОТ, дүрэмт хувцас, тусгай хэрэгслийн зардал зэрэг багтсан болно.

6. Үйлчлүүлэгч тал нь хамгаалалтын байгууллагад үйлчилгээний төлбөрийг сард 2 удаа төлөх ба сар бүрийн 10 болон 25-ны дотор төлбөрийг ХААН банкны 510 700 5093 тоот дансанд шилжүүлнэ.

7. Хамгаалалт үйлчилгээний төлбөрийг төлөх ёстой хугацаандаа төлөх ба тодорхойгүй шалтгааны улмаас хэтрүүлсэн тохиолдолд хэтэрсэн хоног тутамд нийт төлбөрийн 1,5% -тай тэнцэх алданги төлнө.



8. Оролцогч талууд гэрээний биелэлтийг улирал тутамд дүгнэж, шаардлагатай гэж үзвэл гэрээг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар нарийвчлан тохиролцож байна.

9. Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл оролцогч талууд албан ёсоор бичгээр мэдэгдэж, харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэж байна.

10. Үйлчлүүлэгч нь үйлчлэгчид төлөх төлбөрөөс хоёр тал албан ёсоор харилцан тохироогүй, харуул хамгаалалтанд холбоогүй, шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй, маргаантай асуудалтай холбогдсон төлбөрийг дур мэдэн суутгахыг хориглоно.

11. Энэхүү гэрээний хугацаанд МУ-ын Засгийн газраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэх, бараа бүтээгдэнхүүн, шатахууны үнийн өсөлтөөс хамаарч хамгаалагч тал гэрээний үнэнд өөрчлөлт оруулах саналыг тавьсан тохиолдолд талууд цаг тухайд нь харилцан тохиролцож нэмэлт оруулах ба гэрээнд нэмэлтээр өөрчлөгдсөн дүнг оруулсан өдрөөр тооцож авна.

#### **ГУРАВ: ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТАЛЫН ЭРХ,ҮҮРЭГ**

1. Үйлчлүүлэгч тал нь хамгаалж буй объектын гэрэлтүүлэг, хаалганы бэхэлгээ, цоож, лац, ломбо, тоног төхөөрөмжтэй холбогдох хэрэгсэл /компьютер, диск, хард диск/ нууцлалын зэрэглэлтэй өрөө, тасалгааг хамгаалалтын ажилтанд өдөр бүр хүлээлгэж өгнө.

2. Хамгаалалтын албаны ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэх шаардлагатай орчин нөхцлийг бүрдүүлэх, байгууллагынхаа холбогдох ажилтнуудын хаягийн бүртгэл, хамгаалалтанд байгаа объектод нэвтрэх эрх бүхий хүмүүсийн болон эд хөрөнгөтэй харьцах, захиран зарцуулах хүмүүсийн нэрс, албан тушаал, утасны жагсаалтыг гаргаж өгөх .

3. Объектын дотор мөнгөн тэмдэгт, алт, үнэт эдлэл зэргийг үлдээхдээ тусгай зориулалтын хүндрүүлэгчтэй сейфэнд хадгална.

4. Галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор цахилгаан хэрэгсэл болон цахилгаан түгээгүүрүүдэд байнга хяналт тавьж шалгалт хийж илэрсэн дутагдлыг цаг тухайд нь засаж, ажил тарсны дараа цахилгаан хэрэгслүүдийг хүчдэлээс салгасан байна.

5. Объектын үйлчилгээний нэр төрөл, ажлын цагийн хуваарийн өөрчлөлт,



объектыг хаах нээх эрх бүхий хүнийг /үйлчлүүлэгчийн хуудсанд бичигдсэн/ ажлаас чөлөөлсөн, халагдсан зэргийг хамгаалалтын албанд дор бүр мэдэгдэх

6. Үйлчлүүлэгч байгууллага гэмт халдлага, хор аюул учруулж болзошгүй талаар сэжиг бүхий мэдээ, мэдээлэл авсан тохиолдолд хамгаалалтын албанд нэн даруй мэдэгдэж шаардлагатай арга хэмжээг хамтран авах.

7. Харуул хамгаалалтын албан хаагчийн үйл ажиллагаа, харьцааны соёлд хяналт тавьж, зөрчил дутагдал илэрвэл хамгаалалтын албанд нэн даруй мэдэгдэж шаардлага тавих, харуул хамгаалалтын алба хаагч, бие хүнийг солиулах хүртэл санал тавих эрхтэй.

8. Үйлчлүүлэгч тал нь шаардлагатай үедээ хамгаалалтын албанаас нэмэлт хүч авах. Үүнд: а. Баяр ёслолын үед б. Үйлчлүүлэгч талын аюулгүй байдалд хүндрэл гарах үед. Жич: нэмэлт хамгаалалт авсан үед төлбөрийг цагаар тооцож хөлсөө тохиролцож авна.

9. Хамгаалалтын албаны /хамгаалалтын ажилтаны /зүгээс гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар тавьсан хууль ёсны санал, шаардлагыг тухай бүрт нь хүлээн авч шийдвэрлэх

10. Хамгаалалтын ажилтныг албан үүрэгтэй нь холбогдуулан шагнаж болно. Энэ тохиолдолд хамгаалалтын албанд урьдчилан мэдэгдэнэ.

11. Хамгаалалтын ажилтан албан үүргээ биелүүлж яваад амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгийн хувьд хохирсон, гэмтэж бэртсэн тохиолдолд материаллаг болон санхүүгийн тусламж үзүүлж болно.

12. Үйлчлүүлэгч тал нь хамгаалж буй объектод онцгой объект /банкны салбар, валют арилжааны цэг, үнэт эдлэл, нууцлалын зэрэгтэй өрөө тасалгаа, нууц материал, зураг схем/ зэрэг байгууллага нэмэгдсэн тохиолдолд хамгаалалтын албанд мэдэгдэж гэрээний 3.1, 3.2, 3.3, 3.4-р зүйлд заасныг танилцуулж хэрэгжүүлэх үүрэгтэй.

13. Объектын түрээсийн байгууллагаас авах хамгаалалтын үйлчилгээний төлбөрийг үйлчлүүлэгч тал хариуцна.

14. Хамгаалалтанд өгсөн барилга байгууламж болон тодорхой орчин газарт гадны байгууллагын хамгаалалтын үйлчилгээг давхардуулахгүй байх.

15. Үйлчлүүлэгч байгууллага нь хамгаалалтын албаны ажилтанд дур мэдэн эд зүйл барьцаанд авч мөнгө төгрөг өгөх, зээлдүүлэхийг хатуу хориглоно.

16. Хамгаалалтын ажилтныг үүргээ гүйцэтгэхэд нь шаардлага хангасан байр,



шөнийн цагаар орчныг хянах бололцоотой гэрэлтүүлэг, ширээ сандлаар, хангах асуудлыг үйлчлүүлэгч тал хариуцна.

17. Үйлчлүүлэгч тал хамгаалалтын алба хаагчдад зайлшгүй шаардлагатай эд зүйлсийг буюу бараа материал, эд хөрөнгийг албан ёсоор хариуцлагатай хүлээлгэж өгөх ба тоо ширхэгээр нь хүлээлгэн өгсөн, хүлээн авсан гарын үсгээр баталгаажсан тэмдэглэл хөтлөх.

18. Байгалийн гэнэтийн аюул үзэгдлээс үүссэн хохирлыг үйлчлүүлэгч тал бүрэн хариуцна.

### **ДӨРӨВ: ХАМГААЛАГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ**

1. Хамгаалалтанд байгаа объект түүний онцлог байдлаас хамаарч хамгаалалт зохион байгуулах талаар үйлчлүүлэгч талтай харилцан мэдээлэл солилцон ажиллах

2. Мэдээлсэн гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, гарсан хэрэг, зөрчил, гэмт халдлагыг таслан зогсоох.

3. Хамгаалалтын нөхцлийг сайжруулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сөрөг үр дагаврыг арилгуулах талаар санал, шаардлагыг үйлчлүүлэгч талд тавьж биелэлтийг шалгах

4. Хамгаалалтын ажилтнуудыг албан ёсоор томилж тэдэнд гэрээнд заасан ажил үүргийг нарийн танилцуулж, мэргэжлийн удирдлагаар хангах

5. Хамгаалалтын албаны ажилтнууд үйлчлүүлэгч талын болон өөрийн харьяа байгууллагын дотоод журмуудыг мөрдөн ажиллах үүрэгтэй. Хамгаалалтын үйлчилгээний холбоотой санал хүсэлт, гомдол шаардлагыг тухай бүр хүлээн авч шуурхай шийдвэрлүүлэн хариуг амаар болон бичгээр үйлчлүүлэгч талын эрх бүхий ажилтанд өгнө.

6. Ажлын дадлага туршлагатай, соёлч боловсон харилцаатай, хамгаалалтын албанд тэнцэх бие бялдар, эрүүл мэндийн шаардлага хангасан 20-оос дээш насны хүмүүсээс бүрдсэн бүрэлдэхүүнээр амгаалалтын объектыг хамгаалах.

7. Хамгаалалтын ажилтныг алба хаагчийн дүрэмт хувцас, таних тэмдэг бусад шаардагдах тусгай хэрэгслээр хангах

8. Хамгаалалтын алба хаагчтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний дагуу хариуцлага, сахилга бат, дэг журам, ажлын үр дүнг харгалзан шийдвэрлэж байх.



9. Хамгаалалтын ажилтан ажил үүргээ гүйцэтгэж яваад амь бие, эрүүл мэндээр хохирсон тохиолдолд хууль тогтоомжид заасан тусламж үзүүлэх
10. Хамгаалалтын ажилтныг нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, хүн амын орлогын албан татварт хамруулах
11. Хамгаалалт хийхдээ Нийслэлийн Цагдаагийн Газар, Хэв Журмын хэлтэс болон тухайн орон нутгийн Цагдаагийн газар хэлтэстэй хамтран ажиллах
12. Хамгаалалтын албанаас хамгаалалтын найдвартай орчинг бүрдүүлэх талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүйгээс үүссэн хохиролд МУ-ын Хөдөлмөрийн хуулийн 132-р зүйлийн 4-т зааснаар хариуцлага хүлээхгүй.
13. Харуул хамгаалалтын алба түүний алба хаагч нь "Гэрээт харуул хамгаалалтын тухай" Монгол Улсын хуульд заагдсан бусад эрх үүргүүдийг биелүүлнэ.
14. Хамгаалалтын алба нь хамгаалалтанд авсан объектод гэрээний 3,14-т зааснаар гадны хамгаалалтын байгууллагыг давхар ажиллуулахгүй.
15. Хамгаалалтын алба ба "Хамгаалалтын алба хаагч" нь энэхүү гэрээний 3,17-д зааснаас бусад тохиолдолд үйлчлүүлэгч талын хүлээлгэж өгөөгүй эд зүйлс дутах буюу алга болсон тохиолдолд ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

#### **ТАВ: ТАЛУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯЗГААРЛАЛТ**

1. Талууд хамгаалалтаас бусад асуудлаар дотоод үйл ажиллагаанд оролцохгүй байх
2. Талууд хууль, ёс зүйг хүндэтгэн үзэж хоёр байгууллагын болон хувь хүний нууцыг хуулийн хүрээнд хамгаалж хадгална.
3. Талууд бие биенийхээ хууль ёсны эрх ашиг сонирхлыг харилцан хүндэтгэж, тэдний зөвшөөрөлгүйгээр аливаа мэдээлэлийг иргэн, хуулийн этгээд, хэвлэл мэдээлэлийн байгууллагад ярилцлага, мэдээлэл явуулахгүй байх
4. Иргэд, хуулийн этгээдийн амь нас, эрүүл мэнд алдар хүнд эд хөрөнгийг аюултай байдалд хүргэхүйц үйл ажиллагаа явуулахгүй байх.
5. Монгол Улсын хуулийн эсрэг болон төр засгийн хууль ёсны төлөөлөгчийн эсрэг үйл ажиллагаа явуулахыг хамгаалагч талд шаардах эрхгүй.
6. Аль ч тал албан ёсны зөвшөөрөлгүйгээр гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ хууль ёсны залгамжлагчаас бусад гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхгүй.

7. Талууд зөвхөн харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

### **ЗУРГАА: БУСАД**

1. Хамгаалалтанд байгаа объект нь байгалийн гамшигт өртөх /газар хөдлөлт, үер ус, гал түймэр, хүчтэй салхи шуурга гэх мэт/ гоц халдварт өвчний улмаас улсын онцгой комиссын тогтоосон хорио цээрийн бүсэд хамрагдсан тохиолдолд хамгаалалтын жигд үйл ажиллагаанд саад бэрхшээл учруулахаар бол хамгаалалтыг татан буулгаж учирсан хохиролд хариуцлага хүлээхгүй.
2. Улс орон даяар нийтийг хамарсан жагсаал цуглаан, үймээн самууны үед хамгаалалтанд байгаа объектод гарсан хохиролд хариуцлага хүлээхгүй.
3. Энэхүү гэрээ нь талуудын гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр үйлчилж эхлэх ба гэрээний нөхцөл биелэгдсэнээр буюу гэрээ цуцлагдсанаар дуусгавар болно.
4. Гэрээ монгол хэл дээр 2 хувь үйлдэх ба талуудад тус бүр нэг нэг хувь хадгалагдсан нь адил хүчинтэй болно.

### **ДОЛОО: МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ**

1. Гэрээ хэрэгжих явцад гарсан аливаа маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

### **НАЙМ: НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ**

.....  
.....  
.....  
.....

### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

“ЭМ БИ БИ БИ ТИ” ХХК-ийг

төлөөлж:

Харуулын албаны дарга

\_\_\_\_\_ Н.Дашпунцаг

Үйлчлүүлэгч талыг төлөөлж:

Стратеги төлөвлөлт, санхүү  
бүртгэлийн албаны дарга

\_\_\_\_\_ Ч.Батболд